

ЦАГДАА БАЙГУУЛЛАГААС АЛБА ХААГЧИЙГ ТЭТГЭВЭРТ ГАРАХАД БАРИМТЛАХ БОДЛОГО

Б.Дэнзэнноргой

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 7081дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн хурандаа

Хураангуй: Цагдаагийн алба хаагч нь цагдаагийн байгууллагаас төрийн өмнө хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тангараг өргөсөн төрийн тусгай албан хаагч ба албан үүргээ биелүүлэхийн тулд тодорхой эрх эдэлж, эдийн засгийн болон нийгмийн баталгаагаар хангагдах ёстой бөгөөд энэхүү баталгааг нь төр хариуцдаг.

Цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал их, цалин бага байгаа нь цагдаагийн албанд орж ажиллах залуучуудын эдийн засаг, нийгмийн баталгааг бүрэн хангаж чадахгүй, залуу насаа цагдаагийн албанд өнгөрүүлж буй залуучуудын хувьд 20-25 жил тасралтгүй ажиллаж 40-45 насандаа тэтгэвэр тогтоолгон албанаас чөлөөлөгдөж байна.

Цагдаагийн алба хаагчийн тэтгэвэрт гарахын өмнөх карьер төлөвлөлтийг хийж тухайн алба хаагч тэтгэвэр тогтоолгох хугацаанаас 6-12 сарын өмнө “ДАСАН ЗОХИЦОХ” хөтөлбөрт хамрагдан тэтгэвэрт гарсны дараах ажлын байрыг бий болгох чухал ач холбогдолтой.

Мөн алба хаагчийг тэтгэвэрт гарахын өмнөх бие эрүүл мэнд, сэтгэл зүйн тал дээр бэлтгэн 6-12 сарын дараа ажлаа өгөх хугацаанд түүнийг орлон гүйцэтгэх алба хаагчийн бэлтгэснээр цагдаагийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх бүрэн боломжтой.

Abstract: A police officer is a special state official who has sworn to uphold the duties entrusted by the state to combat crime, protect public order, and ensure public safety. In order to fulfill these duties, police officers are granted specific rights and must be provided with economic and social security, which is the responsibility of the state. However, the heavy workload and low salaries of police officers often fail to fully meet the economic and social security needs of young people entering the police force. As a result, many spend their youth in the service and retire after 20-25 years of continuous work, at the age of 40-45.

To address this, it is crucial to plan the career transition of police officers before retirement by enrolling them in an "Adaptation" program 6-12 months prior to the retirement period. This program helps prepare officers for their post-retirement employment opportunities, ensuring a smoother transition.

Additionally, preparing officers for retirement by focusing on their physical and mental health, as well as training a replacement during the 6-12 months before they retire, will strengthen the human resources capacity of the police organization and ensure a seamless transition of duties.

Түлхүүр үг: Цагдаагийн алба хаагч, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал, төрийн тусгай албан хаагч,

ажлын ачаалал, тэтгэвэр тогтоох, дасан зохицох хөтөлбөр, карьер төлөвлөлт, бие эрүүл мэнд, сэтгэл зүй, хүний нөөцийн чадавх

Keywords: Police, crime fighting, public order, public safety, special government employees, workload, retirement, adjustment programs, career planning, physical health, psychology, human resource capacity

Удиртгал:

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааны тухай асуудал нь агуулга, зарчим, мөн чанарын хувьд хүний эрхийн нийгмийн баталгаа гэсэн ойлголттой нийтлэг талтай буюу нэг хэсэг нь гэж хэлж болно.

Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч нар тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулиар зохицуулагддаг.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д, 5 хүртэл жил алба хаасан бол цэргийн алба хаасан нийт хугацаанд авсан цалин хөлсний нийлбэрийг алба хаасан сарын тоонд тус тус хувааж тодорхойлдог.

Цэргийн алба хаасны тэтгэвэр: Цэргийн алба хаагч нь дор дурдсан үндэслэлээр нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байдаг. Үүнд:

- 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй.

- 20-оос доошгүй жил алба хаасан эмэгтэй.

- Байлдааны нисдэг тэрэгний нисгэгчээр 23-аас доошгүй жил цэргийн алба хаасан.

- Байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-оос доошгүй жил цэргийн алба хаасан.¹

Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, хилийн цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, тагнуулын болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын генерал, офицер, ахлагч, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, байлдагч нар авах эрхтэйгээр хуульчилсан.

Цэргийн алба хаасны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тооцож тогтоодог. Мөн дээрх заасан хугацаанаас илүү алба хаасан жил тутамд 1.5, сар тутамд 0.125 хувиар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон цалин хөлснөөс тооцож нэмэгдэл олгодог.²

Нэг удаагийн тэтгэмж: Цагдаагийн алба хаагч эрэгтэй 25-аас доошгүй, эмэгтэй 20-оос доошгүй жил

¹ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Төрийн албаны эмхэтгэл, 2016 он

² Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Төрийн албаны эмхэтгэл, 2016 он

алба хаагаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад түүнд 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно ба харин 10-аас доошгүй жил хаасан цагдаагийн алба хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндээр, түүнчлэн цэргийн алба хаах нас хэтэрч ажлаас чөлөөлөгдвөл түүнд 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгохоор заасан байдаг.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа: Цагдаагийн албаны тухай хуульд нийгмийн баталгааг дараах байдлаар зааж өгсөн байдаг. Үүнд:

- Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.

- Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.¹

Цагдаагийн алба хаагчийн алба хаах нас: “Цагдаагийн албаны тухай” хуульд “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд заасан үндэслэлээр цагдаагийн алба хаагч тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авах эрхтэй бөгөөд алба хаах насны дээд хязгаарыг дараах байдлаар тогтоож өгсөн. Үүнд:

- цагдаагийн бага цолтой алба хаагч 47 нас

- цагдаагийн дунд цолтой алба хаагч 52 нас

- цагдаагийн ахлах цолтой алба хаагч 55 нас

- цагдаагийн дээд цолтой алба хаагч 57 нас

- цагдаагийн бага цолтойгоос бусад эмэгтэй алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар нь 47 нас байна гэж тус тус зааж өгсөн.

Мөн насны дээд хязгаарт хүрсэн цагдаагийн алба хаагчийн алба хаах хугацааг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 хүртэл жилээр сунгаж болно гэж ² заасан байдаг.

Цагдаагийн байгууллагын захиалгаар суралцсан, цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цагдаагийн цолтойгоор ажилласан, цэргийн жинхэнэ алба хаасан, цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан болон хуульд заасан бусад хугацааг цагдаагийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцдог бөгөөд Монгол Улсын иргэн 18 настайдаа ДХИС-ийн Цагдаагийн сургуульд элсэн орлоо гэж тооцох юм бол гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд тасралтгүй 17 жил ажиллах буюу 1 жилийг 1 жил, 3 сараар тооцоход 22 жил, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан 4 жилийг нэмж тооцуулан нийт 35 насандаа цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгох боломжтой болж байна.

Үндсэн хэсэг: Цагдаагийн алба хаагч нь цагдаагийн байгууллагаас төрийн өмнө хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг

¹ Мөн тэнд

² Мөн тэнд

хэрэгжүүлэхээр тангараг өргөсөн төрийн тусгай албан хаагч юм.¹

Өнөөдрийн байдлаар Цагдаа, дотоодын цэргийн албанд 11,063 алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд 1-10 жил ажилласан 6,928, 11-15 жил ажилласан 2,128, 16-20 жил ажилласан 1,524, 21-25 жил ажилласан 350, 26-аас дээш жил ажилласан 133 алба хаагч байна.²

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын гэр бүлийн байдлын хувьд 14.4 хувь нь ганц бие, 59 хувь нь 2-4 ам бүлтэй, 22.6 хувь нь 5-6 ам бүлтэй, 1.5 хувь нь 7-оос дээш ам бүлтэй байна. Амьдрах нөхцөлийн хувьд 44.6 хувь нь нийтийн орон сууц, 19.7 хувь нь хашаа байшин, 15.2 хувь түрээсийн орон сууц, 9 хувь нь гэрт, 6.4 хувь нь айлд, 3.6 хувь нь түрээсийн хашаа байшин, 1.4 хувь нь хувийн хаусд амьдардаг³ ба нийт алба хаагчдын 25.2 хувь нь өөрийн гэсэн орон байргүй байна.

Түрээсийн орон сууц, хашаа байшинд байрлаж буй алба хаагчдын дийлэнх нь орон нутагт томилогдон ажиллаж байгаа бөгөөд тухайн аймаг сумын цагдаагийн газар, хэлтэс, тасгийн хувьд томилогдон очсон алба хаагчдыг түр байрлуулах орон байр хомс байна.

Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйн хэсгээс алба хаагчдаас жил бүр ажлын байрны орчин нөхцөл, ажлын байрны стресс, сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэдэг бөгөөд энд судалгаанд нийт алба хаагчдын 63.2 хувь нь сэтгэл ханамжтай, 36.8 хувь нь дунджаас доош сэтгэл ханамжгүй

үүнээс Нийслэлийн цагдаагийн удирдах газар болон дүүрэг дэх цагдаагийн газруудын алба хаагчдын сэтгэл ханамжийн дунджаас доогуур үнэлгээ өндөр хувьтай гарсан.⁴ Сэтгэл ханамжгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлсэд 47.8 хувь нь цалин хөлс бага, 11.7 хувь нь өөрийгөө хөгжүүлэх боломжгүй, 10.7 хувь нь ачаалал ихтэй гэж үзсэн байна.

Мөн алба хаагчдын 87.2 хувь нь ямар нэгэн зээлтэй ба үүнээс 75 хувь нь цалингийн, 24.8 хувь нь орон сууцны, 6.3 хувь нь автомашины зээлтэй⁵ байна. Ахлагч бүрэлдэхүүний хувьд 12.6 хувь нь хэрэглээний, 9.1 хувь нь аппликейшны зээл, 6.5 хувь нь банк бус санхүүгийн байгууллагын зээл, 3.8 хувь нь бусад төрлийн буюу гэр бүл, ах дүү, найз нөхдөөсөө зээл авсан гэж судалгаанд дурдагдсан.

Цагдаагийн байгууллагаас 2023 онд албанаас чөлөөлөгдсөн 1,015, цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгосон 281, эрүүл мэндийн шалтгаанаар 2 алба хаагч байна⁶. Сүүлийн жилүүдэд алба хаагчид цалин бага, ажлын ачааллаас хамаарч өөрийн хүсэлтээр гарах болсон.

Сүүлийн 5 жилийн байдлаас харахад Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас өөрийн болон бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн 4,864, цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгосон 1,462, эрүүл мэндийн шалтгаанаар 32 алба хаагч тус тус гарсан байна. Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас өөрийн болон бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн

¹ Д.Булганаа, *Цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ*, УБ, 2023 он

² *Цагдаагийн ерөнхий газрын хүний нөөцийн мэдээллийн сан*, 2023 он

³ ЦЕГ-ын "Алба хаагчдын амьжиргааны түвшний үзүүлэлт", 2023 он

⁴ ЦЕГ-ын "Ажлаас халшрах хам шинж өвчин" судалгааны тайлан, 2022 он

⁵ ЦЕГ-ын "Алба хаагчдын амьжиргааны түвшний үзүүлэлт", 2023 он

⁶ *Цагдаагийн ерөнхий газрын хүний нөөцийн мэдээллийн сан*, 2023 он

алба хаагчдын 2,618 буюу 53.8 хувь нь офицер, 2,246 буюу 46.2 хувь нь ахлагч, цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгосон алба хаагчдын 1,041 буюу 71.2 хувь нь офицер, 421 буюу 28.8 хувь

нь ахлагч, эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн алба хаагчдын 24 буюу 75 хувь нь офицер, 8 буюу 25 хувь нь ахлагч бүрэлдэхүүн байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 2. Албанаас чөлөөлөгдсөн алба хаагчдын судалгаа

д/д	Он	Албанаас чөлөөлсөн		Цэргийн байнгын тэтгэвэрт гарсан		Эрүүл мэндийн шалтгаанаар	
		Офицер	Ахлагч	Офицер	Ахлагч	Офицер	Ахлагч
1.	2019 он	475	514	202	84	10	1
2.	2020 он	320	306	127	51	3	5
3.	2021 он	457	333	189	87	2	1
4.	2022 он	781	663	321	120	8	0
5.	2023 он	585	430	202	79	1	1
	Нийт	2,618	2,246	1,041	421	24	8

Цагдаа, дотоодын цэргийн нийт 48 ахмадын хороо, салбар хороо, зөвлөлөөс 44 байгууллагын 5,200 ахмад ажилтан алба хаагч байна. 1 Амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур, эрүүл мэндийн хувьд анхаарах шаардлагатай 246 ахмад ажилтан байгаагаас 52 ахмад ажилтан амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур, 234 ахмад ажилтан эрүүл мэндийн хувьд шалтгаантай байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдаас зорилтод бүлгийн хүрээнд 15-аас дээш жил ажилласан, ойрын хугацаанд цэргийн байнгын тэтгэвэрт суухаар төлөвлөж буй алба хаагчдаас Google form ашиглан судалгааг авсан.

Судалгааг асуулгын аргыг ашиглан авсан бөгөөд 2024 оны 07 дугаар сарын 25-аас мөн оны 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл нийт 87 алба хаагч хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан 87 алба хаагчийн насны байдлаар авч үзвэл 35-

40 насны 5, 41-45 насны 22, 46-50 насны 37, 51-55 насны 15, 56-аас дээш насны 8, мөн судалгаанд оролцсон алба хаагчдын эрэгтэй 78 буюу 90 хувь нь, эмэгтэй 9 буюу 10 хувь нь хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас цэргийн байнгын тэтгэвэр хэзээ суухаар төлөвлөж байгаа талаар асуулга авахад 32 алба хаагч буюу 37 хувь нь 1 жилийн дотор суухаар төлөвлөсөн, 42 алба хаагч буюу 48 хувь нь 1-3 жилийн дотор, 11 алба хаагч буюу 13 хувь нь 4-5 жилийн дотор, 2 алба хаагч буюу 2 хувь нь 6-10 жилийн дотор суухаар төлөвлөж байгаа нь ойрын хугацаанд сууна гэсэн төлөвлөгөөтэй алба хаагч цөөнгүй байна.

Энэ нь Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид эрт цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгож дараагийн шатны буюу энгийн иргэний адил ажил, хөдөлмөр хийж амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн нөхцөл байдалтай

¹ Цагдаа, дотоодын цэргийн ахмадын нэгдсэн хорооны 2023 оны тайлан, 2 дахь тал

шууд уялдаатай байна. Мөн тэдний зүгээс ажил, хөдөлмөр эрхлэнгээ тэтгэвэр мөнгө нэмж авах сонирхолтой байгаа нь илт харагдаж байгаа хэдий боловч 40-өөс дээш насны залуучуудад ажил, хөдөлмөр эрхлэхэд насны байдал нөлөөлөх хүчин зүйлс болдог.

Та цэргийн байнгын тэтгэвэрт суухад бэлэн үү? гэсэн асуултад нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 41 буюу 47 хувь нь тийм гэж хариулсан нь цэргийн байнгын тэтгэвэрт суухаар төлөвлөж байгаа нь илт харагдаж байна. Харин мэдэхгүй гэж 35 алба хаагч буюу 40 хувь нь хариулсан нь урсгалаараа буюу ямар нэг төлөвлөгөөгүй байна.

Цэргийн байнгын тэтгэвэрт гарсны дараа хийх ажлын төлөвлөгөөний талаар судалгаанд хамрагдсан алба хаагчдаас асуухад 28 алба хаагч буюу 32 хувь нь төлөвлөгөөтэй байгаа бол үгүй, төлөвлөгөө байхгүй гэсэн хариултыг дийлэнх олонх 59 алба хаагч буюу 68 хувь нь өгсөн байна. Үүнээс харахад цэргийн байнгын тэтгэвэрт гарахад хэдий бэлэн байгаа боловч цаашид юу хийх, ямар ажил төрөл хийх талаар төлөвлөгөөгүй байна.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас дасан зохицох хөтөлбөр байдаг бол түүнд хамрагдах эсэх талаар асуулга авахад 69 алба хаагч буюу 79 хувь нь хамрагдах саналтай, үгүй шаардлагагүй гэж 8 алба хаагч буюу 9% нь, мэдэхгүй байна гэж 10 алба хаагч буюу 12 хувь нь тус тус хариулсан. Үүнээс харахад цагдаа, дотоодын цэргийн байгууллагад дасан зохицох буюу иргэний нийгэмд шилжих хөтөлбөр нэн чухал болох нь харагдаж байна.

Хэрэв дасан зохицох хөтөлбөр хэрэгжиж эхлэх бол ямар төрлийн мэргэжил эзэмших талаар асуулга

авсан бөгөөд нэг алба хаагч хэд хэдэн мэргэжил эзэмшихээр сонгодог байдлаар зохион байгуулахад гадаад хэл гэж 29, тогооч, нарийн боовчин гэж 35, уран дархан, мужаан 16, оёдолчин 11, хүнд машин механизмын оператор гэж 28, бусад төрлийн мэргэжлээр гэж 64 саналыг тус тус өгсөн байна.

Дасан зохицох хөтөлбөр нь тухай алба хаагчийг хоёр дахь мэргэжил эзэмшүүлэхээс гадна өөр ямар төрлийн үйлчилгээ авах талаар асуулга авахад /нэгээс олон удаа сонгодог байхаар судалгааг авсан/ эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээ 64, сэтгэл зүй 25, бизнесийн зөвлөгөө 59, ямар нэг мэргэжил эзэмших сургалт 45 тус тус санал өгсөн байна. Үүнээс харахад алба хаагчид эрүүл мэнддээ илүү анхаарч байгаа нь тэдний гүйцэтгэж буй ажил мэргэжилтэй нь шууд холбоотой харагдаж байна.

Дүгнэлт: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад насаараа ажиллаж, залуу насаа зориулсан ахмад ажилтан, алба хаагчдыг энгийн иргэн болж нийгэмд хөлөө олоход нь дэмжлэг үзүүлж, нийгмийн баталгааг сайжруулахын тулд тэтгэвэр, чөлөөнд гарах үеийн бодлого, стратегийг шинэчлэн боловсруулж, 3-6 сарын дасан зохицох хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь нэн чухал шаардлага болж байна.


Дэлхийн ихэнх улс орнууд энэ төрлийн бодлого, хөтөлбөртэй байдаг ба зарим улс орнууд цагдаагийн албаны тухай хуульдаа тусгаж өгсөн байдаг.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас тэтгэвэрт гарах гэж байгаа ажилтан алба хаагч нарт 3, 6, 12 сарын дасан зохицох хөтөлбөрт хамруулан бие, сэтгэл зүйг эртнээс бэлдэх шаардлагатай. /Схем 1/

Дасан зохицох хөтөлбөр нь цагдаа, дотоодын цэргийн анги

байгууллага, алба хаагчдын дунд сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдах хөтөлбөр бөгөөд тухайн

жилд цэргийн байнгын тэтгэвэрт гарах алба хаагчдыг бүрэн хамруулах шаардлагатай.



Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийг ажилтан, алба хаагч гаргаснаар дасан зохицох хөтөлбөр хэрэгжих бөгөөд тухайн алба хаагчийн нөхцөл байдлаас үүдэн 3-6 сарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай. Хөтөлбөрийг алба хаагчдад тулгах байдлаар хэрэгжүүлж болохгүй бөгөөд өөрсдийнх нь хүсэл сонирхолд нийцсэн байх нь илүү чухал.

Ажлын байран дээрх ачааллыг бууруулах.

Ажлын байран дээрх ачааллыг бууруулахдаа тухайн алба хаагчийн одоо ажиллаж байгаа албан тушаал нэн чухал байдаг. Тасаг, хэлтэс, газар, албадын даргын хувьд ачааллыг бууруулах зорилгоор 6 сарын өмнөөс эхлэн дадлагажих, тухайн албан тушаалд томилогдох дараагийн залуу үеийг дагалдуулах зарчмаар ажлыг хуваарилах зарчмаар аажмаар шилжүүлэх, харин ахлах, чиглэлийн

ахлах албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчдын хувьд удирдлагаас өгч буй үүрэг, даалгаврыг багасгах, дараагийн томилогдох алба хаагчийг мөн адил дагалдуулах байдлаар томилон ажиллуулах, дунд офицер болон ахлагч бүрэлдэхүүний хувьд ачааллыг бууруулах зорилгоор өөр албан тушаалд түр шилжүүлэн ажиллуулах, аль болох сул чөлөөтэй цагийг гаргах арга хэмжээг авах нь чухал.

Ингэснээр алба хаагчид 3-6 сарын өмнөөс өөрийгөө бэлдэж эхлэх бөгөөд энэ хугацаанд эрүүл мэндийн цогц үзлэг, сэтгэл зүйн зөвлөгөө, давхар мэргэжил эзэмших сургалтуудад хамрагдаж болох юм.

Эрүүл мэндийн үзлэг.

Цагдаа, дотоодын цэргийн ажилтан, алба хаагчид жилд нэг удаа гүйцэтгэж буй үүргээс хамаарч дараах төрлийн шинжилгээнүүдэд хамрагддаг. Үүнд:

-Ерөнхий эрүүл мэндийн үзлэг – Биеийн жин, өндөр, цусны даралт, зүрхний үйл ажиллагаа, амьсгалын системийг шалгах.

-Цус, шээсний шинжилгээ – Элгэнд холбогдох үзүүлэлтүүд, сахрын түвшин, цусны бүтэц, хорт хавдар, халдварт өвчнийг илрүүлэх зорилгоор хийгддэг.

-Зүрхний үйл ажиллагаа (ЭКГ) – Зүрхний үйл ажиллагааг тодорхойлж, стрессийн шинж тэмдгийг илрүүлэхэд чиглэгддэг.

-Уушгины үйл ажиллагаа – Амьсгалын системийн үйл ажиллагаа, уушгины багтаамжийг үнэлнэ.

-Сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг – Стресс, сэтгэл зүйн дарамттай холбоотой үзлэг, ярилцлага хийгдэнэ.

-Нүдний үзлэг – Таны харааны чадварыг шалгана.

-Халдварт өвчин – ХДХВ, ДОХ, сүрьеэ зэрэг халдварт өвчнийг илрүүлэх шинжилгээнд хамрагддаг.

Хөтөлбөрийн хүрээнд үүнээс гадна хортой болон хоргүй хавдрын иж бүрэн шинжилгээнд хамруулах нь нэн чухал. Эрт илрүүлэг нь биед урьд өмнө нь мэдэгдээгүй байсан эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг тодруулахад туслах бөгөөд эрт үе шатанд илрүүлэх нь амьдралын хэв маягаа өөрчлөх, түүнээс шалтгаалж үүсэж болзошгүй эмгэгүүдээс урьдчилан сэргийлэх явдал юм.

Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ

Цагдаагийн алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэнд нь ажлын байран дахь өндөр стресс, аюултай нөхцөл байдлуудтай байнга тулгардаг учир онцгой анхаарал шаарддаг. Тэдний сэтгэл санааны байдал нь ажлын гүйцэтгэл, иргэдтэй харилцах харилцаанд шууд нөлөөлдөг тул тогтмол сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь чухал.

Сэтгэлийн дарамт, ядаргаа, сэтгэл гутрал зэрэг асуудлууд алба хаагчдад илүү их тулгардаг учраас сэтгэл зүйн зөвлөгөө авах, сургалтад хамрагдах нь хамгаас үр дүнтэй арга зам болдог.

Цэргийн байнгын тэтгэвэрт гарах нь амьдралын хэв маягт ихээхэн өөрчлөлт авчирч, энэ нь сэтгэл зүйн хямрал үүсгэх нөхцөл болж болзошгүй. Ажил мэргэжлээсээ холдож, тодорхой зорилго, бүтэцтэй амьдралын хэв маяг алдагдах нь ганцаардал, хоосролын мэдрэмж төрүүлэх эрсдэлтэй.

Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллаж байгаа алба хаагчид цэргийн байнгын тэтгэвэрт суусны дараа хэсэг хугацаанд /1-6 сар/ амарсны дараа дахин ажил, хөдөлмөр хийхийг өмнөх судалгаа харуулж байна. Гэвч тэдний дийлэнх нь эзэмшсэн мэргэжлээс хамаарч зөвлөх үйлчилгээ, өмгөөлөгч, харуул хамгаалалтын ажилтан, хуулийн зөвлөхөөр ажилд ордог.

Харин алба хаагчид дахин мэргэжил эзэмших боломжийг олгосноор шинэ карьерын боломжуудыг нээж, өөрсдийн чадамжийг ашиглан тогтмол орлоготой болж, амьдралын хэв маягаа шинэчлэхэд тусална гэж үзэж байна. Жишээлбэл гадаад хэл, мужаан, гар урлал, уран дархан, гагнуурчин, ази-европ хоолны тогооч, нарийн боовчин, оёдолчин, уурхайн хүнд даацын машины оператор гэх мэт.

Мэргэжил олгох сургалтыг алба хаагчийн өөрийн хүсэл сонирхол дээр тулгуурлан аль салбарт ажиллахаас хамаарч ажиллаж байгаа хугацаанд нь зохион байгуулах нь үр дүнтэй.

Санал: Эндээс харахад цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас

цэргийн байнгын тэтгэвэрт гарах алба хаагчдад энгийн иргэний нийгэмд ажиллаж, амьдрахад нь дэмжлэг үзүүлэх бодлогын хүрээнд шийдвэрлэх стратеги, төлөвлөгөө манай цагдаагийн байгууллагад нэн шаардлагатай байна.

Зарим залуус тэтгэвэрт суусны дараа мэргэжлээс шалтгаалсан суурь болон, хавдрын өвчнөөр өвдөж удалгүй хорвоог орхиж байна. Гэтэл тэд ажиллаа хийж байсан бол одоо ч гэсэн амьд байх байсан болов уу гэсэн бодол хамт ажиллагсад, ар гэр, найз нөхдийн дунд байсаар байна.

Бид алба хаагчдынхаа залуу насыг эх орны сайн сайхны тулд зориулсны төлөө одон медалиас өөр зүйлийг өгч чаддаггүй. Тэгвэл тэднийг иргэний нийгэмд хөлөө олоход нь тусалж дэмжих шаардлагатай бөгөөд энэ талаар системчилсэн шат дараатай арга замыг хүний нөөцийн бодлогод нэвтрүүлэх шаардлагатай байна.

Ном зүй:

Дамбажав И, “Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан Монгол үгийн дээж”, УБ, 2010 он

Монгол Улсын Үндсэн хууль, УБ, 1992 он

Д.Лундээжанцан, Ч.Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй,

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ, 2000 он

Доктор Л.Лхагвасайхан, “Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа, онцлог шинж”, УБ, 2022 он

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Төрийн албаны эмхэтгэл, 2016

Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл №08, 2017 он

МУ-ын УИХ-ын тогтоол, “Цагдаагийн албаны тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, УБ, 2022 он

Доктор, дэд профессор Д.Булган, “Цагдаагийн алба хаагчийн эдийн засгийн баталгааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ”, УБ, 2022 он

Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 141 дугаартай тогтоолын хавсралт “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”,

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, УБ, 2018 он

Ашигласан цахим хуудас:

<https://www.legalinfo.mn>

<https://dobromiru.ru>

<https://volok-grad.ru>

<https://pensweb.ru>

<https://www.bundespolizei.de>

<https://www.bmas.de>

<https://www.police1.com/police-jobs-and-careers>